

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ГЭЖ ЯМАР БАЙГУУЛЛАГА ВЭ?

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Бидний амьдралд гэр бүл, сургуультай холбоотой маш олон асуудал өдөр тутам үүсдэг. Эдгээр асуудлыг бид гэр бүлээрээ, ангиараа ярилцаж шийдвэр гаргадаг шүү дээ.



Гэр бүл, ангийн хурал дээр бүгдээрээ ярилцаж асуудлаа шийддэг шиг улс орны өмнө тулгарсан асуудлыг манай улсын 18-аас дээш насны бүх иргэн нэг дор цуглараад шийдвэрлэх боломжтой юу?

Яагаад болохгүй гэж? Сүхбаатарын талбай дээр бүгдээрээ цуглаад усны хомсдол үүсэх аюулаас хэрхэн сэргийлэх талаар ярилцаж шийдвэр гаргаж болно шүү дээ.



【 За тэгвэл нэг тоо бодож үзье. 】

Манай улсад 18-аас дээш насны 2 сая гаруй иргэн байдаг. Хэрвээ, Монгол Улсын 18 нас хүрсэн иргэн бүр хоол идэхгүй бас унтахгүйгээр 1 минут энэ асуудлын талаар өөрийн үзэл бодлоо хэлнэ гэж бодвол нийт 2 сая гаруй минут ярина гэсэн үг.

$$\begin{aligned} 2,000,000 \times 60 \text{ минут} &= 33,333 \text{ цаг} \\ 33,300 \times 24 \text{ цаг} &= 1388 \text{ өдөр} \\ 1388 \times 365 \text{ өдөр} &= 3.8 \text{ жил} \end{aligned}$$

Хөөх, ганцхан асуудлын талаар бараг 4 жил тасралтгүй ярина гэвэл бүтэхгүй юм байна аа.



Тэгэхээр улс эх оронд маань тулгарч буй асуудлаар бүх иргэн нэг дор цуглаад шийдвэр гаргах боломжгүй учраас бид өөрсдийгөө төлөөлөх төлөөлөгчийг сонгож, тэдгээр төлөөлөгчид бидний үзэл бодол, хүсэл зоригт нийцсэн шийдвэрийг гаргах нь хамгийн зөв шийдэл юм. Яг л сурагч бид өөрсдийн хүсэл сонирхлыг илэрхийлэх Сурагчдын зөвлөлийг сонгодогтой ижил гэсэн үг юм.



Ард түмний төлөөлөл болон сонгогдсон гишүүдээс бүрдэж, улс орны хамгийн чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг байгууллагыг ПАРЛАМЕНТ гэнэ. Харин манай улсад парламентыг УЛСЫН ИХ ХУРАЛ гэж нэрлэдэг.

УЛСЫН ИХ ХУРАЛ



УЛСЫН ИХ ХУРАЛ
1 ТАНХИМТАЙ



УЛСЫН ИХ ХУРАЛ
76 ГИШҮҮНТЭЙ



УИХ-ЫН ГИШҮҮД
4 ЖИЛ ТУТАМД
СОНГОГДДОГ



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА УДИРДАНА

яг л Сурагчдын зөвлөлийн дарга шиг



Улсын Их Хурлын даргыг Улсын Их Хуралд 39-өөс дээш суудалтай нам, эвслээс нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно.

Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын сонгуульд 8-аас дээш гишүүн сонгогдсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, илээр санал хурааж сонгоно.

УИХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь **чуулган** байна. Улсын Их Хурлын бүх гишүүдийн нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны хуралдаан болон бусад хуралдаануудыг нийтэд нь **Чуулган** гэж нэрлэнэ.

Улсын Их Хурал аливаа асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Ингэхдээ цөөнхийн саналыг хүндэтгэнэ.



Улсын Их Хурал аливаа асуудлыг **хуралдаанаар хэлэлцэж олонхын саналаар шийддэг** байх нь ээ.

Тэгвэл тэд яг юу хийдэг юм бол?

[УЛСЫН ИХ ХУРАЛ ЮУ ХИЙДЭГ ВЭ?]



Ард түмнийг төлөөлдөг.



Улсын төсөв баталдаг.



Баталсан хуулиа хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьдаг.



Хууль баталдаг.



Төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлдог.

ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Анх 1295 онд Англи улсад парламент үүссэн гэж үздэг. Харин манай улсын парламент хэзээ байгуулагдсан юм бол?



1206 онд Чингис хааныг Хамаг Монголын хаанд өргөмжлөхөд Монгол овог аймгийн язгууртнууд цуглан Их хуралдай хийж шийдвэрлэсэн нь тал талыг төлөөлсөн хуралдаанаар асуудлыг шийдвэрлэж байсан анхны хурлын хэлбэр юм.



Манай Улсын түүхэнд Улсын Дээд, Доод хурал, Улсын Бага Хурал, Ардын Их Хурал зэрэг нэртэй хурлууд байв.



Харин 1990 онд парламентын хамгийн анхны ардчилсан сонгууль болж, байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага Хурал байгуулагдсан. 1992 онд шинэ Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлыг байгуулжээ.





ТҮЛХҮҮР ҮГ




- ✓ Улсын Их Хурал
- ✓ Чуулган
- ✓ Улсын Их Хурлын дарга
- ✓ Улсын Их Хурлын дэд дарга
- ✓ Хууль



ДАСГАЛ АЖИЛ



"Бидний төлөөлөгч" хөлөгт тоглоомоор
4-5 хүүхэд баг болж тоглоно.



ХЯНАЛТЫН АСУУЛТ



1. Улсын Их Хурлыг яагаад ард түмний төлөөллийн байгууллага гэдэг вэ?
2. Улсын Их Хурал хэрхэн бүрддэг вэ?
3. Улсын Их Хурал юу хийдэг вэ?
4. Улсын Их Хурал ямар зарчимд тулгуурлан, хэрхэн шийдвэр гаргадаг вэ?